

Үүний хамт Хятадын Засгийн газар, Монголын талтай найрсаар хэлэлцэн тохиролцох замаар хоёр ард түмний харилцааны асуудлыг шийдвэрлэх тааламжтай завшааныг алдахгүй гэж гүнээ итгэж байгаагаа илэрхийлье. Энэхүү харилцааг гагцхүү Хятад, Монголын ард түмний хэрэг гэж ЗХУ-ын Засгийн газар үзэх боловч Хятад Монгол хоёр ард түмэн өөрсдийн үндэсний эрмэлзэл, шударга ёсны зарчим дээр ах дүү ёсоор найрсаг орших нь Гадаад Монгол ба Зүүн хойд Хятадын эдийн засгийг хөгжүүлэх, ЗХУ-тай тэдгээрийн эдийн засгийн болон бусад хэлхээ холбоог зузаатгахад тус дөхөм үзүүлнэ гэж ЗСБНХУ-ын Засгийн газар баяртай байх болно гэжээ.

«Известия Улан-Батор хото» 1925 оны 4 дүгээр сарын 9, № 170.
Үргэлжлэл бий.

Он цаг, тоо баримт

ХОЙД, ӨМНӨД СОЛОНГОС: ЭДИЙН ЗАСГИЙН ЯЛГАА

	Өмнөд Солонгос	Хойд Солонгос
1. Үндэсний нийт бүтээгдэхүүн /ҮНБ/ БНАСАУ-ын засгийн газрын мэдээгээр /1988 он/ 1 хүнд ногдох ҮНБ		2530 ам. доллар
Өмнөд Солонгосын “эх орноо нэгтгэх хорооны” мэдээгээр /1989 он/ ҮНБ	210 тэр бум ам доллар	21 тэрбум ам. доллар
1 хүнд ногдох ҮНБ Английн Олон улсын стратегийн хүрээлэнгийн тооцоогоор /1987 он/	4968 ам. доллар	987 ам. доллар
Дотоод нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл /ДНБ/	121,3 тэрбум ам. доллар	45,5 тэрбум ам доллар
2. ДНБ-ын бүтэц /%-аар/	Олборлох үйлдвэр 31,9 Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй 10,2 Бусад салбар 57,2 /1989 он/	Аж үйлдвэр, үйлчилгээний салбар 76,0 Хөдөө аж ахуй 24,0 /1981 он/
3. Санхүүгийн бүтэц: /1989/ Орлого	43 тэрбум ам. доллар	35,7 тэрбум ам доллар
Зарлага	42,3 тэрбум ам. доллар	35,7 тэрбум ам. доллар
4. Батлан хамгаалахад зориулах зардал /1989 он/ /Улсын нийт зардалд эзлэх хувийн жин, %-аар/	9,1 тэрбум ам доллар 21,6%	4,3 тэрбум ам. доллар 12,1%
5. Экспортын нийт хэмжээ	62,4 тэрбум ам. доллар /1989 он/	2 тэрбум ам. доллар /1988 он/
Түнш орнууд %	АНУ 35,3 Япон 19,8 Гонконг 5,9 ХБНГУ 3,9 Англи 3,2 Бусад орон 31,9	ЗХУ 52,6 Япон 19,4 Хятад 14,0 Азийн бусад орнууд 8,1 Баруун европ 3,9 Бусад орон 2,0

	Өмнөд Солонгос	Хойд Солонгос
6. Импортын нийт хэмжээ	61,5 тэрбум ам. доллар /1989 он/	3,2 тэрбум ам. доллар /1988 он/
Түнш орнууд	Япон 28,4 АНУ 25,9 ХБНГУ 4,3 Австрали 3,6 Малайз 2,4 Бусад орон 35,4	ЗХУ 61,1 Хятад 12,2 Япон 8,4 Азийн бусад орнууд 7,8 Баруун Европ 4,5 Бусад орон 6,0
7. Гадаад худалдааны нийт хэмжээ /1989 он/	4,5 тэрбум ам. доллар	900 сая ам. доллар
Гадаадын өр /1989 он/	29,4 тэрбум ам. доллар	6,8 тэрбум ам доллар

Хойд Солонгост 1960-аад оноос эхлэн албан ёсны статистикийн мэдээ хэвлэгдэхээ больсон учир тус улсын эдийн засгийн өнөөгийн байдалд үнэн зөв дүгнэлт өгөхөд хэцүү юм. Цөөн хэдэн мэдээнээс үзэхэд 1 хүнд ногдох ҮНБ-ий үйлдвэрлэл 1978 онд 1920 ам. доллар байсан бол 1988 онд 2530 ам. доллар хүртэл өсжээ. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1989 онд 1946 оныхтой харьцуулахад 554 дахин өсжээ. Үр тарианы үйлдвэрлэл 10 сая тоннд хүрч, одоо 15 сая тоннд хүргэх зорилт тавиад байна. Гэвч гадаад орнуудын тооцоолсон үзүүлэлт нь Хойд Солонгосын Засгийн газрын мэдээллээс хол зөрж байгааг анхаарууштай. Жишээлбэл, Өмнөд Солонгосын «Эх орноо нэгтгэх хороо»-ны тооцоолсноор БНАСАУ-ын ҮНБ-ий үйлдвэрлэл нь 1989 онд Өмнөд Солонгосын 1/10, 1 хүнд ногдох ҮНБ-ий үйлдвэрлэл 15-ээс бага байна.

Японы Азийн эдийн засгийн хүрээлэнгийн Олон улсын харилцааны секторын дүгнэлтээс үзэхэд 80-аад оноос хойш Хойд Солонгос нь «Социалист лагерийн дунд зэргийн хөгжилтэй орны тоонд өрөөсөн хөлөөрөө гишгээд байна. Учир нь:

1) өөрийн хүчинд тулгуурлах бодлогыг баримталж ирснээс үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, техник хуучирсан,

2) цэргийн зардал нь албан ёсны мэдээнээс хол давсан,

3) эдийн засгийн бодлого нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг зорилт болгоогүй зэрэгт оршино.

БНАСАУ

Газар нутаг 120538 км²

Хүн ам 21,9 сая

Мөнгөн тэмдэгт: вон (1989 оны байдлаар 1 ам. доллар нь 0,94 вонтой тэнцэнэ)

БНСУ

Газар нутаг 99237 км²

Хүн ам 42,4 сая

Мөнгөн тэмдэгт вон: (1989 оны байдлаар 1 ам. доллар нь 671,46 вонтой тэнцэнэ)

«НИХОН КЭИЗАЙ ШИМБУН» 1991.10.15.